



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
НИЙСЛЭЛ ДЭХ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

14200 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8 дугаар хороо,
Г.Амарын гудамж, Соёлын төв өргөө, Г корпус, 5 давхар,
Утас: 7000 7734, Факс: (976-11) 32 01 54,
И мэйл: ub@audit.gov.mn, Вебсайт: www.audit.mn

2024.02.23 № 242

танай _____-ны № _____ -т

УЛААНБААТАР ХОТЫН МУЗЕЙН
ЗАХИРАЛ, ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧ
П.ДАВААСҮРЭН ТАНАА

Улаанбаатар хотын музейн 2023 оны
санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн
аудитын тайлан, санал дүгнэлтийг хүргүүлж байна.

Хавсралт 19 хуудастай.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР



М.ЭРДЭНЭЖАРГАЛ

002032860



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Улаанбаатар хотын музейн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: НТАГ-2024/168/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn Улаанбаатар хот 2024 он	“Эс Жи Эм Ди-Аудит” ХХК
	Захирал: Д.Эхбаяр Утас: 70006948 Цахим хаяг: ekhbayar@sgmd-audit.mn
	Аудитын менежер: Д.Насанжаргал Утас: 70006948 Цахим хаяг: nasaa@sgmd-audit.mn
	Ахлах Аудитор: О.Алтанцэцэг Утас: 70006948 Цахим хаяг: info@sgmd-audit.mn
	Аудитын шинжээч: Ч.Ням-Очир Утас: 70006948 Цахим хаяг: c.nyamaa@sgmd-audit.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

1.Хараат бус аудиторын дүгнэлт.....	2
2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл	4
3. Санхүүгийн тайлангийн тодруулга	12
3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа	12
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд	13
3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв.....	14
4. Аудитын тайлан.....	16
4.1 Ерөнхий зүйл.....	16
4.2 Материаллаг байдал.....	16
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт	16
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	17
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	17
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал	18
5. Аудитын илрүүлэлт	18
6. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл.....	19

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
НТАГ	Нийслэл дэх Төрийн аудитын газар
НЗДТГ	Нийслэлийн Засаг Даргын Тамгын Газар
СТА	Санхүүгийн тайлангийн аудит
ТШЗ	Төсвийн шууд захирагч





ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
НИЙСЛЭЛ ДЭХ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

14200 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8 дугаар хороо,
Г.Амарын гудамж, Соёлын төв өргөө, Г корпус, 5 давхар,
Утас: 7000 7734, Факс: (976-11) 32 01 54,
И-мэйл: ub@audit.gov.mn, Вэбсайт: www.audit.mn

2024.02.23 № 243
танай _____-ны № _____-т

УЛААНБААТАР ХОТЫН
МУЗЕЙН ЗАХИРАЛ, ТӨСВИЙН
ШУУД ЗАХИРАГЧ
П.ДАВААСҮРЭН ТАНАА

АУДИТЫН ДҮГНЭЛТ

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Улаанбаатар хотын музейн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Улаанбаатар хотын музейн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Улс болон орон нутгийн төсвөөс нэн шаардлагатай хөрөнгө, эх үүсвэрийг санхүүжүүлсний үр дүнд музейн эд зүйлс, үзмэр, түүх соёлын дурсгалт зүйлсийн сан нэмэгдэж, хадгалалт хамгаалалт сайжирч, түүх соёлын дурсгал зүйлсийн талаар иргэд, хүүхдүүдийн мэдлэг, мэдээлэл нэмэгдэж, байгууллагын санхүүгийн менежмент сайжрах нөхцөл бүрдсэн байна.

Санхүүгийн тайлангийн тухай болон аудитын тайлангийн тухай хэрэглэгчдийн анхаарал хандуулах, ач холбогдолтой зүйлийн талаар тодруулахад санхүүгийн тайланд толилуулаагүй асуудал гараагүй болно.

Байгууллагын удирдлага нь санхүүгийн тайлангаа бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх зарчмыг ашигласан байна. Цаашид тус байгууллагын талаар чиг үүрэг нь өөрчлөгдөж татан буугдах, нэгдэх асуудал гараагүй тул байгууллагын тасралтгүй байдлын талаар нөхцөл үүсээгүй гэж үзсэн болно.

Аудитын гол асуудал

Аудитыг гүйцэтгэхэд аудитын хамрах хүрээний хязгаарлалт хийх шаардлагагүй болон хангалттай, зохистой нотолгоог олж авах боломжгүй нөхцөл үүсээгүй тул бидний олж авсан нотолгоо нь аудитын дүгнэлтийн суурь болоход хүрэлцээтэй, зохистой гэж үзлээ.

Бусад асуудлын хэсэг

Байгууллагын жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 4 зорилтын хүрээнд 23 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөснөөс 96.5 хувийн гүйцэтгэлтэй гэж тайлагнасан байна. Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР



М.ЭРДЭНЭЖАРГАЛ

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	32,742,916.57	43,415,833.86
35	БАРАА МАТЕРИАЛ	32,742,916.57	43,415,833.86
354	Хангамжийн материал	32,742,916.57	43,415,833.86
35410	Бичиг хэргийн материал	1,139,340.00	1,182,540.00
35420	Аж ахуйн материал	458,117.00	1,194,600.00
35440	Түлш, шатах тослох материал	0.00	4,892.00
35470	Бусад хангамжийн материал	31,145,459.57	41,033,801.86
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	610,439,877.81	641,798,331.85
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	610,439,877.81	641,798,331.85
392	Биет хөрөнгө	565,025,137.81	596,952,031.85
39201	Барилга, байгууламж, орон сууц	101,445,362.80	101,445,362.80
39202	Хуримтлагдсан элэгдэл	(50,725,790.55)	(58,282,480.77)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	0.00	43,720,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	0.00	(41,533,999.78)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	33,012,025.95	57,025,184.82
39206	Хуримтлагдсан элэгдэл	(23,418,087.43)	(22,486,787.26)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	10,644,860.00	11,108,850.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	(10,644,860.00)	(8,905,725.00)
39213	Түүх соёлын дурсгалт зүйлс	500,049,319.04	510,149,319.04
39217	Номын фонд	4,662,308.00	4,662,308.00
393	Биет бус хөрөнгө	45,414,740.00	44,846,300.00
39301	Програм хангамж	2,378,400.00	2,378,400.00
39302	Хасагдуулга	(1,809,960.00)	(2,378,400.00)
39303	Бусад биет бус хөрөнгө	44,846,300.00	44,846,300.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	643,182,794.38	685,214,165.71
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	98,218.38	0.00
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	98,218.38	0.00
413	Өглөг	98,218.38	0.00
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	98,218.38	0.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	643,084,576.00	685,214,165.71
51	Засгийн газрын хувь оролцоо	643,084,576.00	685,214,165.71
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	99,872,456.01	99,872,456.01
51101	Өмч:- төрийн	99,872,456.01	99,872,456.01
512	Хуримтлагдсан үр дүн	65,184,919.35	107,314,509.06
51210	Өмнөх үеийн үр дүн	65,184,919.35	65,184,919.35
51220	Тайлант үеийн үр дүн	-	42,129,589.71
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	478,027,200.64	478,027,200.64
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	643,182,794.38	685,214,165.71



2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	365,602,590.00	559,675,948.42
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	2,941,590.00	37,762,808.11
120	Нийтлэг татварын бус орлого	2,941,590.00	37,762,808.11
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	2,605,500.00	4,035,000.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	308,000.00	73,500.00
1200017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого Үндсэн хөрөнгө	0.00	28,013,341.49
1200018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого Бараа материал	28,090.00	5,640,966.62
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	362,661,000.00	521,913,140.31
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	500,000.00	3,200,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	500,000.00	3,200,000.00
1340	Орон нутгийн төсвөөс санхүүжих	362,161,000.00	518,713,140.31
134001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн санхүүжилт/	362,161,000.00	518,713,140.31
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	371,534,989.12	517,525,693.03
21	УРСГАЛ ЗАРДАЛ	371,534,989.12	517,525,693.03
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	347,699,952.59	513,661,193.03
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	255,120,656.48	397,306,651.83
210101	Үндсэн цалин	161,308,839.39	239,509,879.59
210102	Нэмэгдэл	49,225,079.24	76,837,662.39
210103	Унаа хоолны хөнгөлөлт	32,277,491.00	39,516,000.00
210104	Урамшуулал	12,309,246.85	41,443,109.85
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	32,343,666.12	50,294,394.80
210201	Тэтгэврийн даатгал	22,822,479.06	35,447,855.28
210202	Тэтгэмжийн даатгал	2,684,997.57	4,170,335.92
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,033,877.86	3,177,868.67
210204	Ажилгүйдлийн даатгал	436,573.77	681,666.77
210205	Эрүүл мэндийн даатгал	4,365,737.86	6,816,668.16
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	6,204,532.66	8,465,664.34
210301	Гэрэл, цахилгаан	2,809,664.61	3,980,272.76
210302	Түлш, халаалт	2,552,508.05	3,299,338.58
210303	Цэвэр, бохир ус	842,360.00	1,186,053.00
2104	Хангамж, бараа материалын зардал	16,710,652.10	18,590,865.29
210401	Бичиг хэрэг	2,354,157.00	1,343,300.00
210402	Тээвэр, шатахуун	608,290.00	1,171,996.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	3,938,128.59	4,052,420.96
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	522,500.00	967,500.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,590,352.00	1,696,306.00
210408	Бараа материал акталсны зардал	6,697,224.51	9,359,342.33
2105	Нормативт зардал	696,000.00	0.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	696,000.00	0.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,740,200.00	0.00
210604	Урсгал засвар	1,740,200.00	0.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	12,551,744.00	16,255,585.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	8,961,104.00	11,775,645.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	2,600,000.00	2,600,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	0.00	269,100.00

210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	700,000.00	746,000.00
210807	Газрын төлбөр	290,640.00	290,640.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	0.00	574,200.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	22,332,501.23	22,748,031.77
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	200,000.00	0.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	10,480,650.00	7,871,310.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	11,651,851.23	14,876,721.77
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	23,835,036.53	3,864,500.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	8,672,600.00	3,536,000.00
213204	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	6,972,600.00	0.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,700,000.00	3,536,000.00
	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас санхүүжилт	15,162,436.53	328,500.00
	Төвлөрүүлэх шилжүүлэг	15,162,436.53	328,500.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	(5,932,399.12)	42,150,255.39
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	2,952,000.00	20,665.68
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	2,952,000.00	20,665.68
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	(2,952,000.00)	(20,665.68)
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	(8,884,399.12)	42,129,589.71

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	365,574,500.00	526,021,640.31
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	2,913,500.00	4,108,500.00
120	Нийтлэг татварын бус орлого	2,913,500.00	4,108,500.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	2,913,500.00	4,108,500.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	2,605,500.00	4,035,000.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	308,000.00	73,500.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	362,661,000.00	521,913,140.31
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	500,000.00	3,200,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	500,000.00	3,200,000.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	362,161,000.00	518,713,140.31
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	362,161,000.00	518,713,140.31
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	354,262,102.00	507,779,140.31
21	УРСГАЛ ЗАРДАЛ	354,262,102.00	507,779,140.31
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	330,427,065.47	503,914,640.31
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	255,022,438.10	397,404,870.21
210101	Үндсэн цалин	161,210,621.01	239,608,097.97
210102	Нэмэгдэл	49,225,079.24	76,837,662.39
210103	Унаа хоолны хөнгөлөлт	32,277,491.00	39,516,000.00
210104	Урамшуулал	12,309,246.85	41,443,109.85
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	32,343,666.12	50,294,394.80
210201	Тэтгэврийн даатгал	22,822,479.06	35,447,855.28
210202	Тэтгэмжийн даатгал	2,684,997.57	4,170,335.92
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,033,877.86	3,177,868.67
210204	Ажилгүйдлийн даатгал	436,573.77	681,666.77
210205	Эрүүл мэндийн даатгал	4,365,737.86	6,816,668.16
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	6,204,532.66	8,465,664.34
210301	Гэрэл, цахилгаан	2,809,664.61	3,980,272.76
210302	Түлш, халаалт	2,552,508.05	3,299,338.58
210303	Цэвэр, бохир ус	842,360.00	1,186,053.00
2104	Хангамж, бараа материалын зардал	7,740,408.59	9,770,725.96
210401	Бичиг хэрэг	1,386,680.00	1,487,000.00
210402	Тээвэр, шатахуун	420,000.00	1,140,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	3,938,128.59	4,052,420.96
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	522,500.00	967,500.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,473,100.00	2,123,805.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,230,000.00	00.00
210604	Урсгал засвар	1,230,000.00	00.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	18,702,220.00	25,771,325.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	12,511,580.00	21,040,585.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	5,200,000.00	2,600,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	00.00	269,100.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	700,000.00	746,000.00
210807	Газрын төлбөр	290,640.00	290,640.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	00.00	825,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	9,183,800.00	12,207,660.00

210901	Бараа үйлчилгээний бусад зардал	200,000.00	00.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	8,983,800.00	12,207,660.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	23,835,036.53	3,864,500.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	8,672,600.00	3,536,000.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	6,972,600.00	00.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,700,000.00	3,536,000.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	15,162,436.53	328,500.00
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	15,162,436.53	328,500.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	<u>11,312,398.00</u>	<u>18,242,500.00</u>
	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	<u>00.00</u>	<u>00.00</u>
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	11,312,398.00	18,242,500.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	11,312,398.00	18,242,500.00
2200	Дотоод эх үүсвэрээр	11,312,398.00	18,242,500.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	11,312,398.00	18,242,500.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	<u>(11,312,398.00)</u>	<u>(18,242,500.00)</u>
	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	<u>00.00</u>	<u>00.00</u>
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	00.00	00.00
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	00.00	00.00
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	00.00	00.00

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
1	2022 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	99,872,456.01	478,027,200.64	74,069,318.47	651,968,975.12
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	99,872,456.01	478,027,200.64	74,069,318.47	651,968,975.12
4	Дахин үнэлгээний өсөлт	-	-	-	-
7	Тайлант үеийн үр дүн	-	-	(8,884,399.12)	(8,884,399.12)
8	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	99,872,456.01	478,027,200.64	65,184,919.35	643,084,576.00
10	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-
11	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	99,872,456.01	478,027,200.64	65,184,919.35	643,084,576.00
16	Тайлант үеийн үр дүн	-	-	42,129,589.71	42,129,589.71
17	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	99,872,456.01	478,027,200.64	107,314,509.06	685,214,165.71

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	хувь
1	Мөнгө, түүнтэй адилгах хөрөнгийн эхний үлдэгдэл				
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	551,243,000.00	522,493,140.31	28,749,859.69	94.8%
21	УРСГАЛ ЗАРДАЛ	551,243,000.00	522,493,140.31	28,749,859.69	94.8%
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	546,243,000.00	518,957,140.31	27,285,859.69	95.0%
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	402,456,500.00	397,404,870.21	5,051,629.79	98.7%
210101	Үндсэн цалин	228,686,600.00	239,608,097.97	(10,921,497.97)	104.8%
210102	Нэмэгдэл	97,580,300.00	76,837,662.39	20,742,637.61	78.7%
210103	Унаа хоолны хөнгөлөлт	45,980,000.00	39,516,000.00	6,464,000.00	85.9%
210104	Урамшуулал	30,209,600.00	41,443,109.85	(11,233,509.85)	137.2%
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	50,307,100.00	50,294,394.80	12,705.20	100.0%
210201	Тэтгэврийн даатгал	34,208,800.00	35,447,855.28	(1,239,055.28)	103.6%
210202	Тэтгэмжийн даатгал	4,024,600.00	4,170,335.92	(145,735.92)	103.6%
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,219,700.00	3,177,868.67	41,831.33	98.7%
210204	Ажилгүйдлийн даатгал	804,900.00	681,666.77	123,233.23	84.7%
210205	Эрүүл мэндийн даатгал	8,049,100.00	6,816,668.16	1,232,431.84	84.7%
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	12,331,600.00	8,465,664.34	3,865,935.66	68.7%
210301	Гэрэл, цахилгаан	4,032,100.00	3,980,272.76	51,827.24	98.7%
210302	Түлш, халаалт	4,402,700.00	3,299,338.58	1,103,361.42	74.9%
210303	Цэвэр, бохир ус	3,896,800.00	1,186,053.00	2,710,747.00	30.4%
2104	Хангамж, бараа материалын зардал	11,418,000.00	11,120,725.96	297,274.04	97.4%
210401	Бичиг хэрэг	1,488,000.00	1,487,000.00	1,000.00	99.9%
210402	Тээвэр, шатахуун	1,200,000.00	1,140,000.00	60,000.00	95.0%
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	4,135,200.00	4,052,420.96	82,779.04	98.0%
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1,360,000.00	967,500.00	392,500.00	71.1%
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	3,234,800.00	3,473,805.00	(239,005.00)	107.4%
2105	Нормативт зардал	300,000.00	00.00	300,000.00	0.0%
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	300,000.00	00.00	300,000.00	0.0%
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,300,000.00	1,300,000.00	0.00	100.0%
210601	Багаж, техник, хэрэгсэл	1,300,000.00	1,300,000.00	0.00	100.0%
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	52,373,000.00	38,163,825.00	14,209,175.00	72.9%
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	46,386,700.00	33,433,085.00	12,953,615.00	72.1%
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	2,600,000.00	2,600,000.00	0.00	100.0%
210803	Даатгалын үйлчилгээ	269,100.00	269,100.00	0.00	100.0%
210804	Тээврийн хэрэгслийн гатвар	69,200.00	00.00	69,200.00	0.0%
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	748,000.00	746,000.00	2,000.00	99.7%
210807	Газрын төлбөр	300,000.00	290,640.00	9,360.00	96.9%
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	2,000,000.00	825,000.00	1,175,000.00	41.3%

2109	Бараа үйлчилгээний бусад зардал	15,756,800.00	12,207,660.00	3,549,140.00	77.5%
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	15,756,800.00	12,207,660.00	3,549,140.00	77.5%
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	5000000.00	3536000.00	1,464,000.00	70.7%
2132	Бусад урсгал шилжүүлэг	5,000,000.00	3,536,000.00	1,464,000.00	70.7%
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	5,000,000.00	3,536,000.00	1,464,000.00	70.7%
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	551,243,000.00	522,493,140.31	28,749,859.69	94.8%
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	547,463,000.00	518,384,640.31	29,078,359.69	94.7%
132001	Орон нутгийн төсвөөс	547,463,000.00	518,384,640.31	28,078,359.69	94.7%
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	3,780,000.00	4,108,500.00	(328,500.00)	108.7%
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	3,780,000.00	4,035,000.00	(255,000.00)	106.7%
120045	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	0.0	73,500.00	(73,500.00)	
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	00.00	00.00	0.00	0.00
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	00.00	00.00	0.00	0.00
6	ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ				
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	1	1		-
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	19	19		-
	Удирдах ажилтан	1	1		
	Гүйцэтгэх ажилтан	13	13		
	Үйлчлэх ажилтан	5	5		

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Гүйцэтгэл
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	3,200,000.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	3,200,000.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	3,200,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр	3,200,000.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр хураамж	3,200,000.00
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	3,200,000.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	3,200,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	3,200,000.00

3. Санхүүгийн тайлангийн тодруулга

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Улаанбаатар хотын музей нь Улаанбаатар хотын түүхэн хөгжлийн явцад бий болсон биет соёлын өв, эд өлгийн зүйлийн хайгуул судалгааг хийж, сан хөмрөгийг баяжуулах, музей судлал, сан хөмрөгийн үзмэр, Улаанбаатар хотын хөгжлийн түүхийн чиглэлээр эрдэм шинжилгээ судалгааны ажил явуулах, музейн үндсэн чиглэлийг шинжлэх ухааны үндэслэлтэй боловсруулж, үзмэрийг Улаанбаатар хотын түүхийн судалгааны сүүлийн үеийн үзэл баримтлал, ололтод тулгуурлан, шинэлэг шийдэл, зохимжтойгоор дэглэн нийтийн хүртээл болгох үүрэгтэй байгууллага юм.

Улаанбаатар хотын музейн төв эрхэм зорилгоо “нийслэл хотын хөгжлийн түүх, соёлын өвийг баримтжуулан хадгалж, хамгаалах, хойч үедээ уламжлуулах, иргэдийн оюуны эрэлт хэрэгцээг хангах, тэдний боловсролыг дээшлүүлэхэд дэмжлэг үзүүлэх” гэж тодорхойлсон байна.

Тайлант оны онцлог үйл явдлууд:

1. Тайлант онд Соёлын сайдын багцын хүрээний хөрөнгө оруулалтаар 27,895.3 мянган төгрөгийн өртөг бүхий камер, дохиолол хамгааллын системүүдийн тоног төхөөрөмжийг нийлүүлэн ашиглалтад оруулсан байна.
2. Музейн үзмэр, сан хөмрөгийг нэмэгдүүлэх зорилгоор урлаг судлаач иргэний хувийн цуглуулгаас 9 дэсийн 10 ширхэг эд өлгийн зүйлийг гэрээ байгуулан 9,600.0 мянган төгрөгөөр худалдан авсан.
3. “Нийслэл хот үүсэн байгуулагдсаны 385 жилийн ой”-д зориулсан эмхэтгэлд 8 нэр төрлийн 54 ширхэг үзмэрийн зүйлсийн зургийг оруулан Нийслэлийн иргэдийн хүртээл болгосон.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд дараах өөрчлөлтүүд орсон байна. Үүнд:

- Засгийн газрын 2023 оны 241 дүгээр тогтоолоор баталсан ‘Төрийн албаны зарим албан тушаалын цалингийн хэмжээ, доод хэмжээг шинэчлэн тогтоох тухай’
- ЗГ-ын 2023 оны 301 дүгээр тогтоолоор “Төрийн жинхэнэ албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөөг боловсруулж батлах, үр дүн, мэргэжлийн түвшинг үнэлэх журам” баталж 9 дүгээр сараас хэрэгжиж эхэлсэн.
- ЗГ-ын 442-р тогтоолоор Журам шинэчлэн батлах тухай” Засгийн газрын 2023 оны 08 дугаар сарын 23-ны өдрийн 301 дүгээр тогтоолын хавсралтаар баталсан “Төрийн жинхэнэ албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулж батлах, ажлын гүйцэтгэл, үр дүн, мэргэшлийн түвшинг үнэлэх журам”-ын тав дугаар бүлэгт өөрчлөлт орж 12 дугаар сараас хэрэгжиж эхэлсэн байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.



Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Улаанбаатар хотын музейн 2023 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Байгууллагын мөрдөж буй нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийн талаар: Улаанбаатар хотын музей нь захирлын 2017 оны А/07 дугаар тушаалаар баталсан Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг мөрдөн ажиллаж байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Улаанбаатар хотын музейн 2023 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагааны бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 42,129.6 мянган төгрөгөөр буюу 6.5 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Бараа материал	32,742.9	43,415.8	10,672.9
Үндсэн хөрөнгө	610,439.9	641,798.4	31,358.5
Нийт хөрөнгө	643,182.8	685,214.2	42,031.4
Өр төлбөр	98.2	0.0	(98.2)
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	643,084.6	685,214.2	42,129.6
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	643,182.8	685,214.2	42,031.4

Дээрх хүснэгтээс харахад өмнөх оны үзүүлэлтээс нөлөө бүхий өөрчлөлт гарсан авлага, үндсэн хөрөнгө, өр төлбөрийн дансдууд байна.

Бараа материал дансны үлдэгдэл 43,415.8 мянган төгрөг болж 10,672.9 мянган төгрөгөөр нэмэгдсэн нь байгууллагын хэвийн үйл ажиллагааг хангах зорилгоор төсвийн хөрөнгөөр 30,870.3 мянган төгрөгийн бараа материал худалдан авч,

Соёлын яамнаас үнэ төлбөргүй болон хандивын орлогоор 5,641.0 мянган төгрөгийн бараа материал нэмэгдэж, 16,479.1 мянган төгрөгийн материал зарцуулж, 9,359.3 мянган төгрөгийн бараа материалыг акталсан зэргээс шалтгаалсан байна.

Бараа материалын дансны үлдэгдэлд ашиглалтгүй байгаа болон их хэмжээгээр худалдан авч нөөцөлсөн материал байхгүй байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 641,798.4 мянган төгрөг болж 31,358.5 мянган төгрөгөөр нэмэгдсэн нь төсвийн хөрөнгөөр 18,242.5 мянган төгрөгийн хөрөнгө худалдан авч, Нийслэлийн төр захиргааны авто баазаас эрх бүхий байгууллагын шийдвэрээр 43,720.0 мянган төгрөгийн тээврийн хэрэгсэл, Соёлын яамнаас 22,291.2 мянган төгрөгийн тоног төхөөрөмж, бусад байгууллагуудаас 500.0 мянган төгрөгийн түүх, соёлын дурсгалт зүйлс тус тус үнэ төлбөргүй шилжүүлэн авч, эрх бүхий байгууллагын шийдвэрээр 6,435.9 мянган төгрөгийн хөрөнгийг данснаас хассантай холбоотой байна.

Өр төлбөр дансны үлдэгдэл 98.2 мянган төгрөгөөр буурсан нь ажилчидтай холбоотой өглөгийг барагдуулсантай холбоотой.

Өмчийн өөрчлөлтийн тайлангаар цэвэр хөрөнгө өмчийн дүн өмнөх оноос 42,031.4 мянган төгрөгөөр нэмэгдсэн нь тайлант үеийн үр дүнгээс шалтгаалсан байна.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт:

Тус байгууллагын 2023 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг орон нутгийн төсвөөс 546,239.5 мянга, үндсэн үйл ажиллагааны орлогоос 3,780.0 мянга нийт зарлагыг 550,019.5 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн төслийн саналаас зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 29,212.9 мянган төгрөгөөр бууруулж 520,806.6 мянган төгрөгөөр баталсан байна. Үүнд: Цалин хөлс, НДШ-ийн зардлыг 95,615.8 мянган төгрөгөөр нэмэгдүүлж, бараа үйлчилгээний зардлыг 124,828.7 мянган төгрөгөөр бууруулж баталсан байна. Энэ нь 2023 оны төслийг боловсруулахдаа бараа үйлчилгээний зардлыг бодитой, үндэслэлтэй боловсруулаагүй, цалин хөлс, НДШ-ийн зардал нэмэгдсэн нь 2022 оны эцэст Засгийн газрын зүгээс төрийн албан хаагчдын цалин нэмэгдүүлсэн шийдвэр гаргаснаас шалтгаалсан байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд батлагдсан төсвийг 30,436.4 мянган төгрөгөөр нэмэгдүүлж тодотгон 551,243.0 мянган төгрөг болгосон байна.

Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 5 арга хэмжээг санхүүжүүлэхээр 547,463.0 мянган төгрөгийг орон нутгийн төсвөөс, 3,780.0 мянган төгрөгийг үндсэн үйл ажиллагааны орлогоос бүрдүүлэхээр байна.

Гүйцэтгэлээр орон нутгийн төсвөөс 518,713.1 мянган төгрөгийн санхүүжилт авч үндсэн үйл ажиллагаанаас 4,108.5 мянган төгрөгийн орлого бүрдүүлж, урсгал үйл

ажиллагаандаа 522,493.1 мянган төгрөг зарцуулж үлдэгдэл 328.5 мянган төгрөгийг төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 522,493.1 мянган төгрөг буюу 94.8 хувьтай байгаа нь цалин хөлстэй холбоотой зардлыг 5,051.6 мянга, ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэлийн зардлыг 12.7 мянга, байр ашиглалттай холбоотой тогтмол зардлыг 3,865.9 мянга, хангамж, бараа материалын зардлыг 297.3 мянга, нормативт зардлыг 300.0 мянга, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйл төлбөр хураамжийн зардлыг 14,209.2 мянга, бараа үйлчилгээний бусад зардлыг 3,549.1 мянга, бусад урсгал шилжүүлгийг төгрөгөөр 1,464.0 мянган төгрөгөөр тус тус дутуу зарцуулсантай холбоотой байна.

Хүснэгт 2. Улсын төсвийн Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

/мянган төгрөгөөр/

д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
1.	71702 Соёл урлаг	551,243.0	522,493.1	28,749.9	94.8
1.1	80101 Үндсэн үйл ажиллагааны зардал	504,618.0	490,145.2	14,472.8	97.1
1.2	80215 Эрдэм шинжилгээ, судалгааны ажил	15,000.0	11,103.9	3,896.1	74.0
1.3	80802 Ажил олгогчоос олгох тэтгэмж, урамшуулал, дэмжлэг	5,000.0	3,536.0	1,464.0	70.7
1.4	81905 Музейн үзмэр худалдан авах	18,500.0	9,600.0	8,900.0	51.9
1.5	81908 Түүх соёлын дурсгалт зүйлийг хамгаалах	8,125.0	8,108.1	16,915.0	99.8

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтийн дансаар НЗДТГ-аас 2,900.0 мянган төгрөг, Соёлын өвийн үндэсний төвөөс 300.0 төгрөгийн орлого бүрдүүлж, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр хураамж зардалд зарцуулсан байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав

3.5.4 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр

Тайлант онд хэрэгжүүлсэн төсөл, хөтөлбөр байхгүй болно.

3.5.5 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл

Тайлант онд худалдан авах ажиллагааны төлөвлөгөө батлуулаагүй, гүйцэтгэл байхгүй.

4. Аудитын тайлан

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Улаанбаатар хотын музейн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Мөн байгууллагын үйл ажиллагааг сайжруулах, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахтай холбоотой өгсөн зөвлөмжийг тусгасан болно.

Аудитыг “Эс Жи Эм Ди Аудит” ХХК-ийн аудитор О.Ганчимэг, аудитын шинжээч Ч.Ням-Очир нар гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Д.Насанжаргал, захирал Д.Эхбаяр, НТАГ-ын санхүү-нийцлийн хэлтсийн аудитын менежер Я.Алтэнцэцэг, хэлтсийн дарга Х.Түвшинбаяр нар тус тус хэрэгжүүлсэн.

Улаанбаатар хотын музейн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Эс Жи Эм Ди-Аудит ХХК-д 2024 оны 01 дүгээр сарын 22-ний өдрийн 12 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг дунд гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2022 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлаас 1.5 хувиар буюу 5,573.0 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор байгууллага нь байр ашиглалттай холбоотой тогтмол зардал болон үндсэн үйл ажиллагаатай холбоотой, зайлшгүй шаардлагатайгаас бусад бүх төрлийн зардал, төсөл, арга хэмжээг тэвчиж, батлагдсан төсөвт зардлыг хэмнэх арга хэмжээ авч ажилласан байна.

Энэ хуулийн хүрээнд байр ашиглалттай холбоотой тогтмол зардлыг 3,865.9 мянга, бусад тэвчиж болох зардлыг 1,317.8 мянган төгрөгөөр дутуу зарцуулж нийт 5,183.7 мянган төгрөгийн хэмнэлтийг бий болгожээ.

Төрийн хэмнэлтийн тухай хуульд заасан хангамж болон үйл ажиллагаанд тавих хязгаарлалт, хэмнэлтийн горимыг мөрдөж ажилласан эсэхийг ирүүлсэн судалгааны үр дүн нөхцөл байдлаас үзэхэд байгууллагын албан хэрэгцээнд ашиглаж буй Волксваген маркийн 03-16 УНУ улсын дугаартай тээврийн хэрэгсэл нь улсын дугаар цэнхэр дэвсгэртэй, албан ажлын хэрэгцээнд ашиглагддаг. Автомашин ашиглахтай

холбоотой 1,040.0 мянган төгрөгийн зардлыг гаргасан. Дуудлагын тээврийн хэрэгсэл ашигладаггүй, орлогч дарга, зөвлөх ажилладаггүй, цахим дэлгүүрээс хийсэн худалдан авалт байхгүй байна.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан "Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам"-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан 12 төрлийн мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Тайлант онд нийт 634,347.3 мянган төгрөгийн 36 мэдээллийг байршуулахаас 629,347.3 мянган төгрөгийн 35 мэдээллийг бүрэн байршуулж, 5,000.0 мянган төгрөгийн 1 мэдээллийг байршуулаагүй байна. Үүнд:

- Шилэн дансны цахим системд цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 5,000.0 мянган төгрөгийн орлогын 1 гүйлгээг мэдээлээгүй нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3 "тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх", 6 дугаар зүйлийн 6.4.5 "цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр" заалттай нийцэхгүй, "нийцсэн бөгөөд зохистой байх" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Шилэн дансны цахим хуудсанд мэдээллийг бүрэн байршуулж, биелэлтийг ирүүлэх, зөрчлийг давтан гаргахгүй байх зөвлөмж өглөө.

4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

ТБОНӨХБАҮХАТХ хууль, тогтоомжтой холбоотой хэрэгжилтийг түүвэрлэн үзэхэд материаллаг хэмжээний зөрчил илрээгүй болно.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн нь Шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцээгүй, бусад хууль тогтоомжийн хүрээнд шалгасан зүйлийг холбогдох шалгуурт нийцэж байна гэж дүгнэлээ.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Улаанбаатар хотын музейн 2023 оны эхний хагас жилийн санхүүгийн тайланд хийсэн завсрын аудитаар 98.2 мянган төгрөгийн 1 зөрчил илэрч зөвлөмж өгсөн.



Завсрын аудитаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилтийг шалгахад 1 зөвлөмжийг хэрэгжүүлж ажилласан байна.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар тогтоосон 3,202.9 мянган төгрөгийн 1 албан шаардлага, 1,450.0 мянган төгрөгийн 2 зөвлөмжийн хэрэгжилт 100.0 хувьтай байна.

Хүснэгт 4 Албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Албан шаардлага	1	3,202.9	1	3,202.9	100
Зөвлөмж	2	1,450.0	2	1,450.0	100
Нийт дүн	3	4,652.9	3	4,652.9	100

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн тайлант хугацаанд музейн үзмэр, сан хөмрөг, түүх соёлын дурсгалт зүйлийн биет байдал, бодит үнэ цэнийг шалгах нь зүйтэй гэж үзлээ.

5. Аудитын илрүүлэлт

Аудитаар нягтлан бодох бүртгэлийн тайлагналтай холбоотой алдаа¹, зөрчил илрээгүй, аудитын явцад санхүүгийн тайланд залруулга хийлгээгүй.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2024 оны 5 дугаар сарын 25-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/.


6. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл



Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулбал зохих мэдээллээс таван сая төгрөгөөс дээш орлогын 5,000.0 мянган төгрөгийн дүнтэй 1 гүйлгээг шилэн дансанд мэдээлээгүй.	1	5,000.0			-	-	1	5,000.0
Дүн	1	5,000.0	-	0.0	-	-	1	5,000.0

УЛААНБААТАР ХОТ
АУДИТЫН ТАЙЛАНГ
ЭС ЖИ ЭМ ДИ
УОН8996 5050286

Хянасан: “Эс Жи Эм Ди Аудит” ХХК-ийн
Захирал  Д.Эхбаяр

Бэлтгэсэн:
Аудитор  О.Ганчимэг
Аудитын шинжээч  Ч.Ням-Очир